



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2026 оны 04 сарын 03 өдөр

Дугаар A/126

Улаанбаатар хот

2026 оны ээлжит цэрэг халах, татах ажлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Цэргийн албаны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2, 13.4, 13.6 дахь хэсэг, Засгийн газрын 2018 оны 382, дүгээр тогтоол, Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын 2026 оны мн/12 дугаар тушаал, Нийслэлийн Засаг даргын 2026 оны А/429 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Дүүргийн хэмжээнд 2026 оны нэгдүгээр ээлжийн цэргийн жинхэнэ албаны татлагыг 05 дугаар сарын 01-ний өдрөөс 03-ны өдрүүдэд зохион байгуулж, дүүргийн цэрэг татлагын товчоог хавсралтаар баталсугай.

2. Цэрэг татлагын ажилд шаардагдах зардлыг дүүргийн Засаг даргын Тамгын газрын холбогдох зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газар (Ж.Тамир)-т зөвшөөрсүгэй.

3. Дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэхийг дүүргийн Цэрэг татлагын товчоонд даалгасугай

3.1. Дүүргийн “Цэрэг татлагын товчоо”-ны дарга болон гишүүдийн ажил, үүргийн хуваарийг тогтоож, цэрэг халалт, татлагын талаарх эрх зүйн баримт бичгүүдийг сурталчлан, зааварчилгаа өгч, цэрэг татлагын ажлыг хуулийн дагуу зохион байгуулж, гүйцэтгэлд нь хяналт тавьж ажиллах;

3.2. Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 140 дугаар тогтоолоор батлагдсан “Иргэнийг цэргийн жинхэнэ албанд эрүүл мэндээр тэнцүүлэх болон цэргийн алба хаагчийн эрүүл мэндийн байдлыг тодорхойлох журам”-ыг баримтлан иргэдийг цэргийн жинхэнэ албанд тэнцүүлэн авч, өгөгдсөн тоон даалгаврыг бүрэн биелүүлэх талаар удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжилтийг бүрэн хангах;

3.3. Ээлжит цэрэг татлагын ажилд төрийн захиргааны байгууллагын албан тушаалтан болон мэргэжлийн байгууллагын ажилтныг томилон, гүйцэтгэх ажил үүргийг тодотгон зааварчилгаа өгч, албан хэрэг хөтлөлтийн стандартыг бүрэн хангаж, шаардлагатай маягт, анкетыг хэвлүүлж мөрдөж ажиллах;

3.4. Цэрэгт татагдагчдад эрүүл мэндийн үзлэг явуулах байр, нарийн мэргэжлийн эмч, сувилагч нарыг сонгон авч, холбогдох зааварчилгааг өгч,

мэргэжлийн удирдлага, эмнэлгийн багаж төхөөрөмжийн хэвийн найдвартай ажиллагааг хангах;

3.5.Цэрэг татлагын үед нийгмийн хэв журам сахиулах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, цэрэгт татагдагчдыг тээвэрлэх автомашины техникийн бүрэн бүтэн байдалд үзлэг, шалгалт хийж, жолооч нарын үүрэг хариуцлагыг дээшлүүлэн, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах талаар шаардлагатай арга хэмжээг авах;

3.6.Цэргийн жинхэнэ албанд татагдах зарлан дуудах мэдэгдэл авсан иргэний үүргийг таниулж, тогтоосон хугацаанд заасан байранд ирүүлэхийг хорооны Засаг дарга, ажлын албадаас удирдлага, зохион байгуулалтын олон талт арга хэмжээ авч хэрэгжүүлж ажиллах;

3.7.Цэргийн жинхэнэ албанд татах зарлан дуудах мэдэгдэл аваад тогтоосон хугацаанд, заасан байранд ирээгүй цэргийн үүрэгтний шалтгаан нөхцөлийг тогтоон, татлагад бүрэн хамруулах, хуулийг хэрэгжүүлэх талаар бүх шатанд санаачилгатай ажиллах;

3.8.Цэргийн жинхэнэ албаны татлагаар эрүүл мэндээр тэнцээгүй залуучуудад эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх чиглэлээр төлөвлөгөө гарган, зохион байгуулалтын арга хэмжээг авч үр дүнг тооцох;

3.9.Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын 2014 оны А/50 дугаар тушаалаар баталсан “Улаанбаатар цэргийн хүрээний ёс журам сахиулах ангид иргэнийг хугацаат цэргийн албан хаагчаар сонгон авах журам”-ын заалтыг хэрэгжүүлэх;

3.10.Цэрэг татлага явуулсан тухай дүн, мэдээг цэрэг татлага дууссан өдрөөс хойш 3 хоногийн дотор Нийслэлийн цэрэг татлагын товчоонд хүргүүлэх;

3.11.Цэрэг татлагын байранд ажиллах бүрэлдэхүүний ажлын бүтээмжийг алдагдуулахгүй байхаар ажлын байр, амт чанартай халуун хоол, тээврийн хэрэгслээр хангах ажлыг зохион байгуулах;

3.12.Цэрэгт татагдагч болон цэрэг татлагаар ажиллах бие бүрэлдэхүүний ажиллах байрны ариутгал, цэвэрлэгээг тогтмол сайтар хийж гүйцэтгэн халдвараас сэргийлэх бүх талын арга хэмжээг авч ажиллах;

3.13.Хөдөлмөрийн тухай хуулийн 109 дүгээр зүйлийн 1 заалт, “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам”-ын дагуу амралтын өдрүүдэд ажилласан бие бүрэлдэхүүнд нөхөж нэмэгдэл хөлс бодож олгох;

3.14.Цэргийн жинхэнэ албаны хугацаа дуусгаж, бэлтгэлээр халагдан ирж байгаа цэргийн үүрэгтнүүдийг тусгай хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу хүлээн авах ажлыг зохион байгуулалтын өндөр түвшинд хийж, ажлын байранд зуучлах, мэргэжил олгох сургалтад хамруулах, нэгдсэн, төвлөрсөн байдлаар зохион байгуулахыг албад, хэлтсийн дарга нарт үүрэг болгосугай;

3.15.Цэрэг татлагын товчоо байрлах сургууль, анги, танхимуудыг бүрэн чөлөөлж, цэрэг татлагын байр, танхимуудыг бэлэн болгож, 04 дугаар сарын 29-ний өдрийн 09:00 цагт Цэрэг татлагын товчоонд хүлээлгэн өгөхийг Боловсролын хэлтэс (Ц.Цолмонбаатар), 5 дугаар сургуулийн захирал, цэрэг татлагын байрын дарга (Н.Гэндэнсүрэн)-д тус тус хариуцуулсугай.

3.16.Цэргийн алба хаах насны залуучуудад зарлан дуудах мэдэгдлийг хорооны Засаг даргын ажлын албаны бүрэлдэхүүн болон хэсгийн ахлагч нар гардуулан өгч, зарлан дуудах мэдэгдлийн тооцоог нэг бүрчлэн хийж, хаягийн зөрчилтэй иргэдийн судалгааг гаргаж арилгах чиглэлээр тодорхой ажил төлөвлөн зохион байгуулж ажиллахыг Цэргийн штаб (хурандаа Б.Энхболд), Улсын бүртгэлийн хэлтэс (Д.Оюунбилэг)-т тус тус үүрэг болгосугай.

3.17.Цэрэг татах ажлыг зохион байгуулсан дүнг 2026 оны 05 дугаар сарын 05-ны өдөр танилцуулахыг Цэрэг татлагын товчоо (Ж.Тамир)-т даалгасугай.

4.Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Н.Бямбагэрэл)-т хариуцуулсугай.

ЗАСАГ ДАРГА



Н.МАНДУУЛ